

## VISA APPLICATION CHECKLIST

### ВИЗ МЭДҮҮЛЭГЧИЙН БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

Sporting Events and Competitions - Спортын тэмцээн уралдаан, арга хэмжээнд оролцох

Name: Нэр:	Passport number: Паспортын дугаар:		
Phone: Утас:	Visa fee: Визийн хураамж:		
Required documents Шаардлагатай бичиг баримт		Yes Тийм	No Үгүй
1.	<b>Application form:</b> completed and signed by applicant <b>Шенгений визийн маягт:</b> бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөсөн виз мэдүүлэгч эсвэл хууль ёсны асран хамгаалагч гарын үсгээ зурсан маягт 1 хувь		
2.	<b>One recent biometric passport photograph:</b> in color, size 35x45mm, white or light grey background <b>Цээж зураг:</b> 35x45 мм харьцаатай, биометр шаардлагад нийцсэн, цайвар саарал эсвэл цагаан фонтой, сүүлийн 3 сарын дотор авахуулсан 1 хувь зураг (маягт дээр наахгүй)		
3.	<b>Passport:</b> valid at least three months beyond the end of the planned trip, passport must be signed by passport holder and contain at least two blank pages. Old passports containing previous visas should also be submitted <b>Паспорт:</b> сүүлийн 10 жил дотор олгосон, шенгенд байх хугацаанаас багадаа 3 сар илүү хүчинтэй, эзэмшигчийн гарын үсэгтэй, ямар нэгэн дардас (штамп), тэмдэглэгээ, наалтгүй 2 нүүр байх ёстой. Урьд өмнө хэрэглэж байсан гадаад паспортууд		
4.	<b>For foreign residents:</b> Mongolian residence permit and valid Mongolian re-entry visa <b>Гадаадын иргэн:</b> Монгол улсад оршин суух зөвшөөрөл болон Монгол улсад дахин нэвтрэх хүчинтэй виз		
5.	<b>Photocopies of</b> <ul style="list-style-type: none"> <li>- Identity page and signature page of passport</li> <li>- Copies of former Schengen visas and entry and exit stamps</li> <li>- For foreign residents: copy of Mongolian residence permit and copy of valid Mongolian re-entry visa</li> </ul> <b>Хуулбарууд:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад паспортын эзэмшигчийн мэдээлэлтэй болон гарын үсэгтэй нүүр</li> <li>- Урьд өмнө олгож байсан шенгений виз, хилээр орсон, гарсан штамптай нүүр</li> <li>- Гадаадын иргэн: Монгол Улсад оршин суух зөвшөөрөл болон Монгол Улс руу эргэн нэвтрэх хүчинтэй виз</li> </ul>		
6.	<b>Short description of travel purpose, itinerary</b> <b>Аяллын зорилгын бичмэл тайлбар герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт</b>		
7.	<b>Proof of accommodation:</b> Hotel reservation or similar, for the entire duration of the intended stay <b>Байрлах газрын баримт:</b> Шенгенд байх нийт хугацаанд байрлах зочид буудлын захиалга эсвэл түүнтэй адилгах байрлах газрын талаарх баримт		
8.	<b>Proof of transportation:</b> round-trip tickets/reservations for travel to the Schengen area; tickets for travel within the Schengen area, if applicable <b>Тээврийн хэрэгслийн баримт:</b> Шенгений нутаг дэвсгэрт нэвтрэх ба гарах тийзийн захиалга; Шенгений орнуудаар зорчих бол тээврийн хэрэгслийн захиалга		
9.	<b>Invitation letter</b> issued by organizer of event which the applicant is intending to visit; letter must be written on official letter head paper, letter must state clearly <ul style="list-style-type: none"> <li>- Applicant's full name</li> <li>- Exact name and contact details of inviting event organizer</li> <li>- Purpose and duration of visit</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>- Clear statement whether the event organizer will take care of the applicant's costs of accommodation, travel and living expenses or whether the visa applicant will be taking care of their own living expenses</li> </ul>		

	<p><b>Шенген дэх зохион байгуулагчаас илгээсэн урилга.</b> Урилга нь тухайн байгууллагын албан бланк дээр эрх бүхий этгээдийн гарын үсэг болон тамгатай байхаас гадна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Виз мэдүүлэгчийн овог нэр</li> <li>- Урьж байгаа хүний нэр, холбоо тогтоох мэдээлэл</li> <li>- Аяллын зорилго болон үргэлжлэх хугацаа</li> <li>- Шенгений нутаг дэвсэрт байрлах болон амьжиргааны зардлыг урьж буй байгууллага хариуцах бол энэ талаар урилга дээр тодорхой тусгасан байна</li> </ul>		
10.	<p><b>If the event organizer does not cover all expenses of the trip:</b> <b>Proof of sufficient financial means</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>If someone else is paying for expenses:</b> written declaration of the organization who is taking care of expenses along with bank account statement, previous three months, certified by bank or other proof of solvency</li> <li>- <b>If applicant him - or herself is paying for travel expenses:</b> applicant's bank account statement, previous three months, certified by bank</li> <li>- Print out of social security payments from Tutsmashin</li> <li>- If applicable: any other proof of income</li> </ul> <p><b>Арга хэмжээг зохион байгуулагч тал холбогдох зардлыг хариуцахгүй бөгөөд Монгол дахь ямар нэгэн байгууллага зардлыг хариуцах бол:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шенгенд болж байгаа спортын арга хэмжээтэй холбоотой бүх зардлыг тухайн байгууллага бүрэн хариуцаж буйгаа мэдэгдсэн албан бичиг герман эсвэл англи хэл дээрх орчуулгатай ба Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар. Тус байгууллагын дансны сүүлийн 3 сарын хуулга банкны тамга тэмдэгтэй (орчуулах шаардлагагүй).</li> </ul> <p><b>Виз мэдүүлэгч өөрөө зардлаа хариуцах бол:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Виз мэдүүлэгчийн дансны сүүлийн 3 сарын хуулга банкны тамга тэмдэгтэй</li> <li>- Нийгмийн даатгал төлдөг бол ТҮЦ машинаас авсан сүүлийн 1 жилийн лавлагаа (орчуулах шаардлагагүй)</li> <li>- Орлогын эх үүсвэрийг батлах бусад баримт бичиг байгаа бол өгч болно</li> </ul>		
11.	<p><b>Any proof that shows that applicant is qualified to attend event:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Proof of membership in sports team</li> <li>- Previous participation in similar events</li> </ul> <p><b>Виз мэдүүлэгч тухайн спортын төрлөөр тэмцээнд оролцох эрх бүхий тамирчин гэдгийг нотлох баримт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн спортын холбооны гишүүн, Шигшээ багийн тамирчин мөн гэсэн тодорхойлолт</li> <li>- Урьд өмнө ижил төрлийн тэмцээн, уралдаанд оролцож байсан баримт, баталгаа (мандат; нэр бүхий диплом, өргөмжлөл)</li> </ul>		
12.	<p><b>For employees:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Signed and stamped letter from employer on company paper stating address and telephone number of company as well as name, position, duration of employment and proof of leave of absence</li> <li>- Company's business license</li> <li>- Print out of social security payments from Tutsmashin</li> </ul> <p><b>Албан байгууллагын ажилтан, албан хаагч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажил олгогч байгууллагын албан бланк дээр виз мэдүүлэгчийн хашиж буй албан тушаал, ажил эрхэлсэн хугацаа, цалингийн хэмжээ мөн аяллын зорилго болон хугацааг тодорхойлсон албан бичиг герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт</li> <li>- ТҮЦ машинаас авсан сүүлийн 1 жилийн НД-ын лавлагаа (орчуулах шаардлагагүй)</li> </ul> <p><b>For self-employed:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Company's business license</li> <li>- Print out of social security payments from Tutsmashin</li> </ul> <p><b>Хувиараа хөдөлмөр эрхлэгч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээ герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт</li> <li>- Өөрийн эсвэл компанийн дансны сүүлийн 3 сарын хуулга банкны тамга тэмдэгтэй (орчуулах шаардлагагүй) ба орлого батлах бусад баримт</li> </ul>		
13.	<p><b>Travel health insurance:</b> valid for the Schengen Area, minimum coverage 30 000 EUR, for entire duration of intended trip, <b>photocopy</b> of health insurance booklet</p> <p><b>Notice:</b> The insurance policy has to cover a Covid-19 illness with the minimum sum of 30.000</p>		

	<p><b>Аяллын эрүүл мэндийн даатгал:</b> Шенгений нутаг дэвсгэрт хүчинтэй, багадаа 30.000 Евротой тэнцэх нөхөн олговрын хэмжээтэй даатгалыг Шенгенд байх нийт хугацаагаар хийлгэх ёстой бөгөөд даатгалын баримтын эх хувийг хуулбарын хамт өгнө.</p> <p><b>Анхаарах зүйл:</b> Аяллын эрүүл мэндийн даатгал нь Covid-19-р өвчилсөн тохиолдолд мөн багадаа 30.000 Евротой тэнцэх нөхөн олговортой байх ёстой.</p>		
14.	<p><b>For minors (under 18 years old):</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Students: original</b> letter of school with address and telephone number of school, permission of absence</li> <li>- <b>Birth certificate:</b> photocopy of birth certificate</li> </ul> <p><b>Насанд хүрээгүй хүүхэд (18-аас доош насных):</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Сургуулийн тодорхойлолт эх хувиар.</b> Сургуулийн хаяг, холбогдох утасны дугаар бүхий маягт дээр чөлөө олгосон тухай тодорхойлолтыг герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт</li> <li>- <b>Төрсний гэрчилгээ:</b> эх хувь, хуулбар герман эсвэл англи хэл дээрх орчуулгын хамт</li> </ul>		
	<p><b>Signature of both parents of minor in case of joint legal guardianship:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>Please note: father and mother must both be present in person</b> at time of application and sign the visa application, if both parents are mentioned in birth certificate but only one parent has legal guardianship of the minor, please, provide copy of court decision or death certificate</li> </ul> <p><b>Насанд хүрээгүй виз мэдүүлэгчийн эцэг эх хоёрын гарын үсэг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>18 нас хүрээгүй хүүхэд виз мэдүүлэхэд эцэг эх нь заавал биечлэн ирж гарын үсэг зурна.</b> Эцэг эхийн аль нэг нь ганцаар асран хамгаалах эрхтэй бол холбогдох шүүхийн шийдвэр эсвэл нас барсны гэрчилгээг хуулбар орчуулгын хамт өгнө.</li> </ul>		
15.	<p><b>Optional:</b> Any <b>additional documents</b> the applicant might like to provide which clarify the applicant's family and economic circumstances (e.g.: retirees' pension book, proof of ownership of real estate, proof of private business activities, children's birth and marriage certificates, etc.)</p> <p><b>Нэмэлт:</b> Виз мэдүүлэгч өөрийн гэр бүлийн байдал, өөрийн эд хөрөнгө болон санхүүтэй холбоотой <b>нэмэлт баримт хавсаргаж болно.</b> Жишээ нь: үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, бизнес эрхэлдэг баримт, хүүхдүүдийн төрсний гэрчилгээ болон гэрлэлтийн баталгаа, тэтгэврийн дэвтэр, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын лавлага гэх мэт</p>		
<p><b>Please arrange documents in the order given above.</b>  <b>Бүрдүүлсэн бичиг баримтуудаа дээрх дарааллын дагуу эрэмбэлнэ үү</b></p>			
<p><b>Statement of consent:</b>  I understand that missing documents increase the risk that my application is being denied. Even if the documents are complete the Embassy may ask for additional documentation. The provision of all documents does not guarantee that a visa will be granted. Payment of the visa fee does not automatically guarantee that a visa will be issued. The visa and service fees are not refundable in case of visa refusal or if the applicant chooses to suspend the application process. The granting or refusal of visas falls under the sole discretion of the German Embassy, the Visa Application Center has no influence on the final decision. The Visa Application Center is not involved in the decision making process and is not aware of its outcome.</p> <p><b>Хүлээн зөвшөөрөх мэдэгдэл :</b>  Бичиг баримт дутуу бүрдүүлж өгөх нь визийн мэдүүлгийг татгалзах эрсдлийг нэмэгдүүлнэ гэдгийг би ойлгож байна. Бичиг баримт бүрэн гүйцэд байсан хэдий ч Элчин сайдын яамнаас нэмэлт бичиг баримт шаардаж болно. Бичиг баримт бүрэн гүйцэд байх нь мөн визийн хураамжийг төлөх нь Танд виз олгоно гэсэн баталгаа биш. Виз мэдүүлэгч нь өөрийн хүсэлтээр мэдүүлгээ цуцлах, буцаан авах эсвэл татгалзсан хариу авсан аль ч тохиолдолд визийн болон үйлчилгээний хураамжийг буцаан олгохгүй. Виз олгох эсвэл татгалзах нь гагцхүү Герман Улсын Элчин сайдын яамны шийдвэр бөгөөд Визийн Төв нь эцсийн шийдвэрт нөлөө үзүүлэх боломжгүй. Визийн төв нь шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохгүй мөн гарсан үр дүнд хариуцлага хүлээхгүй.</p>			
<p>I hereby acknowledge that I have read and agree to the above statement and give my consent to the Visa Application Center to submit my visa application to the Embassy of Germany.</p> <p>Миний бие дээрх мэдэгдлийг уншиж танилцсан бөгөөд өөрийн визийн мэдүүлгийг Герман Улсын Элчин сайдын яам руу илгээхийг Визийн Төвд зөвшөөрч буйгаа баталж гарын үсгээ зурсан болно.</p>		<p>Applicant Signature:  Виз мэдүүлэгчийн гарын үсэг:  _____</p> <p>Date:  Огноо: _____</p>	